

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/29/-НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261945 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхжин Утас: 261740 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn Аудитор: Д.Болормаа Утас: 261740 Цахим хаяг: bolormaad@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024. 04. 25 № 1164
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 17,011.2 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 15,584.3 сая төгрөгөөр давсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, 14.2.10, 69.3-т заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

- Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 11,577.8 сая төгрөг;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг санхүүжүүлсэн 4,246.2 сая төгрөг.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2023 оны 42 дугаар тогтоолоор Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, 319 дүгээр тогтоолоор Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ыг тус тус байгуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв хооронд нийт 1,192.1 сая төгрөгийн зохицуулалт хийж, урсгал зардлыг санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд Засгийн Газраас зарласан “Шил ажиллагаа”-ны хүрээнд “shilen.gov.mn” цахим системийг ашиглалтад оруулж, 123 байгууллагын 970,355 мэдээллийг байршуулж, Төрийн үйлчилгээг цахимаар түргэн шуурхай хүргэх И-Монголиа 3.0 хувилбарын хэрэглэгчийн тоо 1.7 саяд хүрч, 1233 төрлийн үйлчилгээг хүргэж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж, “Хурдан цэг”-ийг газар зүйн байршлаас үл хамааран нийт 193 цэгт байршуулж, төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтэд тусгасан 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн 1133 арга хэмжээнээс 1060 арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрч, гүйцэтгэлийг 93.6 хувьтай тайлагнасан байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГН



Д.ЗАГДЖАВ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	136,472,408.9	145,936,073.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	36,676,087.4	40,023,437.1
33	АВЛАГА	21,011,398.7	20,941,126.4
34	УРЬДЧИЛГАА	5,852,464.8	11,021,678.2
35	БАРАА МАТЕРИАЛ	12,737,421.6	13,429,960.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	60,195,036.4	60,519,871.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	326,276,228.9	366,787,710.6
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	500.0	155,712.1
37200	Үнэт цаас	500.0	500.0
37300	Урт хугацаат зээл	-	155,212.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	326,275,728.9	366,631,998.5
39200	Биет хөрөнгө	195,217,356.7	220,571,758.3
39300	Биет бус хөрөнгө	124,217,041.9	139,479,454.0
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	6,841,330.4	6,580,786.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	462,748,637.8	512,723,783.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	115,054,085.2	114,459,831.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	33,498,692.6	34,331,089.9
41300	Өглөг	29,879,044.1	28,004,757.5
41400	Урьдчилж орсон орлого	3,619,648.5	6,326,332.4
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	81,555,392.6	80,128,741.8
42200	Урт хугацаат зээл	81,555,392.6	80,128,741.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	347,694,552.6	398,263,951.9
51	Засгийн газрын хувь оролцоо	344,171,517.5	394,740,916.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,863,456.7	6,863,456.7
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	227,806,661.7	227,806,661.7
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	2,538,512.2	2,538,512.2
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	55,391,768.2	76,483,336.3
51200	Хуримтлагдсан үр дүн	17,741,632.4	38,194,762.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	33,829,486.3	42,854,187.7
52	Хяналтын бус хувь оролцоо	3,523,035.2	3,523,035.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	462,748,637.8	512,723,783.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	147,085,654.1	88,277,417.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	121,878,422.5	28,787,400.1
120	Нийтлэг татварын бус орлого	121,878,412.5	28,787,400.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,207,231.6	59,490,017.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	45,532,069.9	67,971,525.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,532,069.9	67,971,525.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,767,078.6	61,618,070.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,222,840.2	15,716,895.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	898,887.6	1,956,302.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,162,555.9	3,232,768.8
2104	Хангамж, бараа материалын зардал	673,996.4	808,769.7
2105	Нормативт зардал	43,278.3	5,339.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,017,360.8	1,433,941.0
2107	Томилолт, зочны зардал	125,590.1	472,025.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,476,213.7	23,418,444.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,146,355.5	14,573,583.7
212	ТАТААС	613,599.9	397,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,151,391.5	5,955,954.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	101,553,584.2	20,305,892.1
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	1,284,614.9	5,525,276.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,122,979.2	8,222,812.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	98,715,219.9	17,608,355.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	245,470,260.2	-	245,470,260.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	245,470,260.2	-	245,470,260.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	4,245,605.7	-	4,245,605.7
7	Өмчид гарсан өөрчлөлт	(33,051.2)	-	(33,051.2)
8	Зарласан ногдол ашиг	(703,482.0)	-	(703,482.0)
9	Тайлант үеийн үр дүн	98,715,219.9	-	98,715,219.9
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	347,694,552.6	-	347,694,552.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,662,024.5	-	3,662,024.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	351,356,577.2	-	351,356,577.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	8,839,620.6	-	8,839,620.6
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(165,531.7)	-	(165,531.7)
17	Өмчид гарсан өөрчлөлт	21,677,940.9	-	21,677,940.9
18	Зарласан ногдол ашиг	(1,403,623.1)	-	(1,403,623.1)
19	Тайлант үеийн үр дүн	17,958,968.0	-	17,958,968.0
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,263,951.9	-	398,263,951.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	275,721,364.1	261,730,569.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	250,514,132.4	202,240,551.8
120	Нийтлэг татварын бус орлого	250,514,132.4	202,240,551.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,207,231.6	59,490,017.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	215,173,935.7	219,607,384.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	215,173,935.7	219,607,384.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	206,782,865.5	212,883,209.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,707,286.5	48,888,657.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,946,200.3	11,808,770.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,358,396.0	20,479,365.9
2104	Хангамж, бараа материалын зардал	14,643,015.4	15,966,950.2
2105	Нормативт зардал	20,192.5	6,667.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	794,508.5	1,253,596.7
2107	Томилолт, зочны зардал	137,078.2	546,817.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	123,332,367.4	110,392,418.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	843,820.7	3,539,966.0
212	ТАТААС	613,599.9	397,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,777,470.3	6,326,674.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	60,547,428.4	42,123,184.6
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	477,197.2	947,440.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	23,772,653.3	37,201,805.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,772,653.3	37,201,805.1
2200	Дотоод эх үүсвэрээр	23,772,653.3	37,201,805.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(23,295,456.1)	(36,254,364.9)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(575,884.9)	(2,521,469.9)
14	Бусад эх үүсвэр	2,400,709.0	1,165,403.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2,976,593.9	3,686,872.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	36,676,087.4	3,347,349.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	36,676,087.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	36,676,087.4	40,023,437.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	69,131,664,700.00	60,387,749,398.28	8,743,915,301.72	87.4
УРСГАЛ ЗАРДАЛ	47,505,727,200.00	39,124,924,001.28	8,380,803,198.72	82.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,786,557,500.00	31,118,917,167.42	7,667,640,332.58	80.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,625,755,000.00	12,777,596,386.49	1,848,158,613.51	87.4
Үндсэн цалин	11,070,267,100.00	8,989,268,753.72	2,080,998,346.28	81.2
Нэмэгдэл	2,578,062,900.00	932,297,037.62	1,645,765,862.38	36.2
Унаа хоолны хөнгөлөлт	753,843,000.00	1,042,190,140.08	(288,347,140.08)	138.3
Урамшуулал	163,582,000.00	1,783,424,240.46	(1,619,842,240.46)	1090.2
Гэрээт ажлын хөлс	60,000,000.00	30,416,214.61	29,583,785.39	50.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,860,489,600.00	1,598,867,086.02	261,622,513.98	85.9
Тэтгэврийн даатгал	1,261,680,700.00	1,093,677,562.49	168,003,137.51	86.7
Тэтгэмжийн даатгал	149,702,300.00	128,668,115.61	21,034,184.39	85.9
ҮОМШӨ-ний даатгал	119,761,800.00	102,373,909.76	17,387,890.24	85.5
Ажилгүйдлийн даатгал	29,940,300.00	24,780,829.23	5,159,470.77	82.8
Эрүүл мэндийн даатгал	299,404,500.00	249,366,668.93	50,037,831.07	83.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,811,662,700.00	1,683,716,752.16	127,945,947.84	92.9
Гэрэл, цахилгаан	781,320,400.00	779,629,118.48	1,691,281.52	99.8
Түлш, халаалт	107,875,500.00	72,737,987.57	35,137,512.43	67.4
Цэвэр, бохир ус	65,047,000.00	53,843,664.71	11,203,335.29	82.8
Байрны түрээс	857,419,800.00	777,505,981.40	79,913,818.60	90.7
Хангамж, бараа материалын зардал	520,702,600.00	469,876,971.77	50,825,628.23	90.2
Бичиг хэрэг	150,161,700.00	144,523,387.00	5,638,313.00	96.2
Тээвэр, шатахуун	54,831,300.00	41,762,340.00	13,068,960.00	76.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	165,907,700.00	127,599,056.77	38,308,643.23	76.9
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,612,100.00	27,749,550.00	3,862,550.00	87.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	118,189,800.00	128,242,638.00	(10,052,838.00)	108.5
Нормативт зардал	20,654,300.00	1,679,000.00	18,975,300.00	8.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,654,300.00	1,679,000.00	18,975,300.00	8.1
Эд хогшил, урсгал засварын зардал	2,585,492,700.00	2,423,025,062.29	162,467,637.71	93.7
Багаж, техник, хэрэгсэл	1,620,963,200.00	1,524,971,883.00	95,991,317.00	94.1
Тавилга	235,000,000.00	189,178,000.00	45,822,000.00	80.5
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	9,174,900.00	4,174,900.00	5,000,000.00	45.5
Урсгал засвар	720,354,600.00	704,700,279.29	15,654,320.71	97.8
Томилолт, зочны зардал	600,188,200.00	452,233,481.90	147,954,718.10	75.3
Гадаад албан томилолт	273,329,800.00	214,662,844.90	58,666,955.10	78.5
Дотоод албан томилолт	268,382,000.00	228,215,737.00	40,166,263.00	85.0

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Зочин төлөөлөгч хүлээн авах	58,476,400.00	9,354,900.00	49,121,500.00	16.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,908,937,100.00	7,611,777,501.89	4,297,159,598.11	63.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,326,253,300.00	2,251,751,954.50	4,074,501,345.50	35.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	30,996,000.00	-	30,996,000.00	-
Даатгалын үйлчилгээ	4,476,200.00	616,020.00	3,860,180.00	13.8
Тээврийн хэрэгслийн татвар	568,500.00	269,828.00	298,672.00	47.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	113,100.00	22,000.00	91,100.00	19.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,443,954,400.00	5,266,328,990.19	177,625,409.81	96.7
Газрын төлбөр	4,136,900.00	4,136,900.00	-	100.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	12,075,200.00	7,824,409.20	4,250,790.80	64.8
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	86,363,500.00	80,827,400.00	5,536,100.00	93.6
Бараа үйлчилгээний бусад зардал	4,852,675,300.00	4,100,144,924.90	752,530,375.10	84.5
Бараа үйлчилгээний бусад зардал	4,496,145,600.00	3,753,058,211.90	743,087,388.10	83.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	356,529,700.00	347,086,713.00	9,442,987.00	97.4
ТАТААС	6,767,540,000.00	6,094,540,000.00	673,000,000.00	90.1
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,697,040,000.00	5,697,040,000.00	-	100.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,697,040,000.00	5,697,040,000.00	-	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,070,500,000.00	397,500,000.00	673,000,000.00	37.1
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,070,500,000.00	397,500,000.00	673,000,000.00	37.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,951,629,700.00	1,911,466,833.86	40,162,866.14	97.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,578,129,000.00	1,576,270,079.36	1,858,920.64	99.9
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,578,129,000.00	1,576,270,079.36	1,858,920.64	99.9
Бусад урсгал шилжүүлэг	373,500,700.00	335,196,754.50	38,303,945.50	89.7
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	116,067,400.00	115,479,301.00	588,099.00	99.5
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,109,000.00	53,100,000.00	1,009,000.00	98.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	203,324,300.00	166,617,453.50	36,706,846.50	81.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,625,937,500.00	21,262,825,397.00	363,112,103.00	98.3

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Барилга байгууламж	8,054,179,000.00	8,054,178,934.00	66.00	100.0
Тоног төхөөрөмж	13,571,758,500.00	13,208,646,463.00	363,112,037.00	97.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	69,131,664,700.00	68,599,579,920.21	532,084,779.79	99.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	60,466,122,500.00	55,398,049,647.07	5,068,072,852.93	91.6
Улсын төсвөөс санхүүжих	60,466,122,500.00	55,398,049,647.07	5,068,072,852.93	91.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,665,542,200.00	13,201,530,273.14	(4,535,988,073.14)	152.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,665,542,200.00	13,201,205,341.14	(4,535,663,141.14)	152.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	324,932.00	(324,932.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,593,455,104.64	(6,593,455,104.64)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	14,799,755,776.57	(14,799,755,776.57)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	937	917	20	97.9
БАЙГУУЛЛАГЫН ТОО	5	5	-	100.0
Төсвийн байгууллага	5	5	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	466	456	10	97.9
Удирдах ажилтан	27	27	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	402	392	10	97.5
Үйлчлэх ажилтан	37	37	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	466	456	10	97.9
Төрийн захиргааны албан хаагч	224	224	-	100.0
Ажлын албаны албан хаагч	7	6	1	85.7
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	38	38	-	100.0
Улс төрийн албан хаагч	2	2	-	100.0
УТҮГ	195	186	9	95.4

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	215,755,437.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	215,755,437.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	156,847,448.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	37,243,500.00
210401	Бичиг хэрэг	-	2,358,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	34,885,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	81,703,948.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	35,098,948.00
210602	Тавилга	-	22,696,000.00
210604	Урсгал засвар	-	23,909,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	37,900,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	37,900,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	58,907,989.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	8,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	8,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	50,907,989.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	50,907,989.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	215,755,437.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	215,755,437.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	169,663,548.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	46,091,889.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Цахим Хөгжил, Харилцаа Холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 12 байгууллагын тайлан нэгтгэснээс 8 байгууллагад "Өөрчлөлтгүй", 2 байгууллагад "Хязгаарлалттай" дүгнэлт өгч, 2 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагч

Аудитаар нийт 2 зөрчил¹ илэрснээс 1 албан шаардлага хүргүүлж, хүний нөөцийн давхардал чиг үүргийн зохион байгуулалтыг сайжруулах 1 зөвлөмж өгсөн.

5.2.1 Албан шаардлага

Тайлант оны аудитаар илэрсэн зөрчил нь өмнөх оноос 121.8 хувиар нэмэгдэж, сайдын дэргэдэх дотоод хяналт хангалтгүйгээс харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 22,498.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 5,487.6 сая төгрөгийн 26 алдааг залруулж, 7.8 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 4,778.1 сая төгрөгийн зөрчилд 29 албан шаардлага хүргүүлж, өмнөх аудитын албан шаардлагын биелэлтийг хангаагүй зөрчилд 3,548.7 сая төгрөгийн 2 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 8,676.6 сая төгрөгийн зөрчилд 27 зөвлөмж өгч, нийцлийн асуудлаар 14,192.2 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага, 245.3 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийг 30-аас доошгүй хувиар бууруулж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хүний нөөцийн болон ажил үүргийн чиг, үүрэг давхардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цахим, хөгжил, харилцаа, холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 10 байгууллагуудын батлагдсан орон тоо 2406, гүйцэтгэлээр 2086 байна. Үүнээс 2-3 албан тушаал давхардуулан эрхэлж буй 140, хавсарсан гүйцэтгэж буй 103 албан хаагчид албан тушаалын үндсэн цалингийн 10-50 хувийн нэмэгдэл авч ажиллаж байна. ЦХХХС-ын харьяа байгууллагуудын албан тушаалын ажил үүргийн хуваарийг оновчтой зохион байгуулаагүй, чиг үүргийн давхардлыг арилгаж, хүний нөөцийн оновчтой бодлогыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн төсвийн ерөнхийлөн захирагч гэж 4.1.36-д "төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.6.3-д “төсвийн захирагч нь өөрийн эрх, үүргээ доод шатны төсвийн захирагчид шилжүүлж болох боловч энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх”, 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.12-т “эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох”, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Засгийн газрын тусгай сан нь улсын төсвийн, орон нутгийн тусгай сан нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хүний нөөцийн ажил үүргийн давхардал, албан хаагчдын албан тушаалын чиг үүргийг тодорхой болгож, албан тушаалын томилгооны давхардлыг арилгах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 5,487.6 сая төгрөгийн 26 алдаа илэрснээс аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТЦҮЗГ	4	62.3			4	62.3	4	62.3				
Үндэсний дата төв УТҮГ	1	2.1			1	2.1	1	2.1				
Монголын цахилгаан холбоо ХК	18	5,279.0			18	5,279.0	18	5,279.0				
Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	3	144.2			3	144.2	3	144.2				
Дүн	26	5,487.6	-	-	26	5,487.6	26	5,487.6	-	-	-	-

Аудитаар нийт 17,011.2 сая төгрөгийн 66 зөрчил илэрснээс, 7.8 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4,778.1 сая төгрөгийн 30 зөрчилд албан шаардлага, 3,548.7 сая төгрөгийн 3 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 8,676.6 сая төгрөгийн 28 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
ЦХХХЯ	6	99.5			3	14.0	3	85.5					
ТЦҮЗГ	5	50.4			2	19.5	3	30.9					
И-Монгол академи УТҮГ	3	84.3					3	84.3					
Үндэсний дата төв УТҮГ	4	87.7			1	21.7	3	66.0					
БНҮҮС	3	51.1			1	-	1	-	1	2	51.1		
Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ	2	50.7			1	9.0	1	41.7					
Монголын Цахилгаан холбоо ХК	29	15,887.8	4	5.2	18	4,237.6	6	8,147.4	1	1	3,497.6		

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Монгол шуудан ХК	4	111.9	1	2.4	1	19.4	2	90.1					
Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ	5	502.2	1	0.2	2	456.9	2	45.1					
Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	3	85.6					3	85.6					
ЦХХХС	2	-			1	-	1	-					
Дүн	66	17,011.2	6	7.8	30	4,778.1	28	8,676.6	2	3	3,548.7	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 14,318.6 сая төгрөгийн 12 зөрчил илэрснээс 14,073.3 сая төгрөгийн 8 албан шаардлага хүргүүлж, 245.3 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
ЦХХХЯ	1	-						1	-
ТЦҮЗГ	1	-						1	-
И-Монгол академи УТҮГ	1	-						1	-
БНҮҮС	1	-			1	-			
Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ	1	118.9			1	118.9			
Дүн	5	118.9	-	-	2	118.9	3	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
ТЦҮЗГ	1	-						1	-
Монголын Цахилгаан холбоо ХК	7	14,251.6			6	14,006.3	1	245.3	
Монгол шуудан ХК	4	67.0			2	67.0	2	-	
Дүн	12	14,318.6	-	-	8	14,073.3	4	245.3	-
Нийт дүн	17	14,437.5	-	-	10	14,192.2	7	245.3	-

